*Гавшгайчдын улсын II зөвлөлгөөний өмнө*

## Гомбосүрэнгийн хүү сайн явна

1966 онд Улаанбаатар хотын техник мэргэжлийн сургуулийг төгсөж хүссэн мэргэжлээ эзэмшсэн Гомбосүрэнгийн Бор аймгийн барилга монтажийн контopт ирж ажиллажээ.

Анх ажилд орсон Борд мэдэхгүй чадахгүй юм, бэрхшээл нилээд тулгарч байсан боловч, бригадын дарга Жамбал, Зөвлөлтийн мэргэжилтэн нарын тусламж дэмжлэгээр ажилдаа улам гаршиж, төлөвлөгөө нормын биелэлт нь улам сайжирч эхэлжээ.

1967 оны сар бүрийн төлөвлөгөө нормоо 170—200 хувь, жилийн төлөвлөгөөгөө 154 хувиар биелүүлж аймгийн аврага цол хүртжээ. Удалгүй барилгачнаас бригадын даргаар дэвшин ажиллах болсон нь Борыг хүнтэй ажиллах арга барилд сурахыг шаардах болов.

Бор хүмүүстэйгээ уйгагүй, гүнд нь орж ажиллахыг эрхэмлэсэн байна.

Бор өөрийнхөө ажлын туршлагаас ярихдаа:

—Ямар нэг хүн өдөр бүрийн хариуцсан ажилтай байдаг. Миний хариуцсан бригадын хувьд ч гэсэн тодорхой норм төлөвлөгөө бий.

Үүнийгээ биелүүлэхэд юуны урьд бэлтгэлээ сайн хийснээс шалтгаална.

Өөрөөр хэлбэл маргаашийн ажлын хэрэгцээгээр өнөөдөр юмаа сайн бэлтгэж бэлэн болгоод өглөө ажлаа шууд эхлэж хийнэ гэсэн үг шүүдээ.

Ингэснээрээ цагийг үр бүтээлтэй ашиглахын гол нөхцөл бүрдэнэ гэж ярив.

Борын энэ хамтач нөхөрсөг зан чанарт нь хамт олон нь баярлаж түүнийг хүрээлэх болжээ.

Хамт ажилладаг нөхөд нь ч СХТБ байгуулах санал гаргахад нь Бор түүнийг дуртай дэмжив.

Ингэж үүрэг амлалт авч ажилласнаасаа хойш хүмүүсийн ажил нь сайжирч улам ойр дотно болсон байна.

Борын бригадынхан ажлын бус цагаар хамт олны хоо хүчээр 8 айлын орон сууцанд уурын халаагуур тавьж, Зөвлөлтийн мэргэжилтний тусламжтайгаар 80—150 диаметр бүхий хаягдал хоолой ашиглан халаах пийшин хийж нэг бүрийг нь 28 төгрөгөөр борлуулж үйлдвэртээ 1300 гаруй төгрөгийн ашиг оруулжээ.

Мөн хамт олноороо кино үзэх, ном унших, нэгнийхээ гэр орноор явж г э р бүлийн хүмүүсийн эрэлт хүсэлтийг хүлээн авч хамт олноороо ярилцан шийдвэрлэх, дундын эргэлтийн фонд байгуулж хэнд юу шаардлагатай байгааг нь авч өгөх, хэн нэгийнхээ амьдралд тохиолдсон зовлон, жаргал баяр баясгаланг хуваалцдаг болжээ.

Ингэж бригад ба ар гэрийн хоорондын холбоог бэхжүүлсэн нь ажлын амжилт гаргах бас нэг үндэс болсон байна.

Тус бригадын х а м т олон нийтээр 10, 7, 4 дүгээр ангийн боловсролыг эзэмшжээ.

Борын ажлын бүтээл, олон түмний итгэл найдвар нь түүний амьдралыг МАХН-тай холбож өгч 1968 онд МАХН—ын гишүүн болгов.

Ийнхүү хамт олныхоо итгэл найдвар, бүтээлч ажиллагаагаар Гомбосүрэнгийн хүү Борын амьдрал нь ч өөдрөг, ажил нь ч амжилттай яваа IV т а в а н жилийнхээ төлөвлөгөөг 3 жил 6 сарын дотор 113,8 хувиар биелүүлсэн дүн харуулж байна.

**Санги-рагчаа**

## ДЭЛХИЙН ХҮН АМ

*Ухуулагч, суртал нэвтрүүлэгч нарт тусламж*

### ДЭЛХИЙН ХҮН АМЫГ ТИВҮҮДЭЭР АВЧ ҮЗВЭЛ

1. **Ази тив** 44,4 сая хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, хүн ам нь 1 миллиард 960 сая буюу дэлхийн хүн амын 56,6 хувь, нэг хавтгай дөрвөлжин километр газарт 45 хүн ноогдоно.

2. **Европ тивд** 10,6 сая ам дөрвөлжин км газар нутагтай бөгөөд 629 сая хүн оршин сууна.

Нэг ам дөрвөлжин км газарт 60 гаруй хүн ноогдоно.

Дэлхийн хүн амын 18,7 хувийг эзлэнэ.

3. **Америк тивд** 42,1 сая ам дөрвөлжин км газар нутагт 480 сая хүн суух ба дэлхийн хүн амын 14 хувийг эзлэх ба 1 ам дөрвөлжин км-т 11 хүн ноогдоно.

4. **Африк тивд** 30,9 сая ам дөрвөлжин км газар нутаг дээр 320 гаруй хүн оршин, дэлхийн хүн амын 9,4 хувийг эзлэх ба 1 ам дөрвөлжин км газарт 11 хүн ноогдоно.

5. **Австрали тивд** 8,5 сая ам дөрвөлжин км газар дээр 18 сая гаруй хүн, дэлхийн хүн амын 0,5 хувь оршин сууна.

Нэг ам дөрвөлжин км газарт 2 хүн ноогдох болно. Хүн амын тоогоор дэлхийд томоохон улсууд гэвэл Хятад барагцаалбал 780 сая, Энэтхэг 510 сая, ЗХУ 241 сая, Пакистан 105 сая, Индонез 104 сая, АНУ 196 сая, Япон 99 сая тус тус болно.

**Д. Дуламжав**

ЭМЧИЙН ЗӨВЛӨЛГӨӨ

### *АМНЫ ХӨНДИЙГ АРЧЛАХ ТУХАЙ*

Шүдийг ариун цэвэр байлгах нь зөвхөн шүдний өвчнөөс төдийгүй бүх бие мах бодийг элдэв өвчнөөс хамгаалах ач холбогдолтой.

Шүдийг цэвэр байлгахад авах арга хэмжээнүүдийн нэг бол өглөө, өдөр, орой өөрөөр хэлбэл хоолны дараа амаа тогтмол зайлж, угааж байх нь сайн үр дүн үзүүлнэ.

Амыг зайлж угаахад шүдэнд орсон хоолны үлдэгдлийг арилгах ба амны хөндийн нянг цэвэрлэж байгаа хэрэг юм.

Туршлагаас үзэхэд угаагаагүй шүдний 1 мг бохир хэсэгт 800 сая нян байдаг бол угаасан шүдэнд 5—6 сая болж цөөрсөн байна.

Амны хөндий бол аль ч талаар нян үржихэд хамгийн тохиромжтой газар юм. Иймээс тогтмол угааж цэвэрлэж байх хэрэгтэй.

Амны хөндийд байсан хоолны үлдэгдэл нь нянгийн нөлөөгөөр задарч шүдэнд хортой бодис үүсгэхээс гадна амыг эвгүй үнэртэй болгодог байна.

Хүүхдийг 3 наснаас нь буюу сүүн шүд ургаж дуусах үеэс эхлэн амыг нь зайлуулж сургах нь зүйтэй.

Түүнчлэн шүдийг цэвэрлэх, бэхжүүлэх, шүдний эдийн ажиллагааг сайжруулахад хоолыг сайн зажилж идэх, ааруул, лууван, алим, ясны хим идэх нь сайн байдаг.

Шүдээ угаахдаа оонуудыг хэрэглэх, сойзоо зөв сонгож авах, сойздохдоо хөндлөн биш ширхэгийн дагуу угаадаг байх хэрэгтэй. Шүдний ариун цэврийн хэрэглэл нь нэг гэрийн хүмүүст тус тусдаа байвал зохино.

**Шүдний их эмч Жанчив**

## *Тайлан сонгуулийн хурал*

Саяхан Заамар нэгдлийн тайлан сонгуулийн хурал болж, нэгдлийн зөвлөлийн тайлан илтгэлийг нэгдлийн дарга Д. Мишигдорж тавив.

1969 онд Заамар нэгдэл 100 эх мал тутмаас хурга 75, ишиг 77, тугал 55, ботго 31-ийг бойжуулсан нь 1968 оныхоос хурга 15,9 хувь, ишиг 7,1 хувь, унага 5,5 хувиар тус тус илүү бойжуулж өндөр амжилт гарган малын зүй бусын хорогдлыг 33 хувиар багасгажээ.

1 дүгээр бригадын малчин Г. Доржсүрэн, З. Алтангэрэл, 2 дугаар бригадын Гэнджав, П. Алтангэрэл нарын олон суурь малын төлийг сайн бойжуулжээ.

Үйлдвэрийн даалгавар хүлээж авсан бүх суурийн 69,7—70,8 хувь нь уртын ноос, ноолуурын төлөвлөгөөг давуулан биелүүлж 1 дүгээр бригадын Г. Доржсүрэн, 2 дугаар бригадын Б. Сандаг нарын суурь тус бүр 100 гаруй кг ноосыг үйлдвэрийн даалгавраас давуулан тушаажээ.

Нутгийн үүлдрийн үнээ бүрээс 1100 л сүү саасан Лхамсүрэн, эрлийз үнээ бүрээс 1300 л сүү сааж сум — нэгдлийн 5 удаагийн аварга болсон Нацаг нарын тэргүүний сайчуул олон байна.

Тус нэгдэл ноос, сүү бэлтгэх төлөвлөгөөг хугацаанд нь биелүүлж, ноос, сүүнээс оруулсан орлогын хэмжээ урьд оныхоос даруй 54—200 мянга гаруй төгрөгөөр өсч, зөвхөн хөдлөшгүй төлөвлөгөөнөөс давуулж тушаасан сүүний үнэ 60 гаруй мянган төгрөг болжээ. Заамар нэгдлийн гишүүд хургыг тэжээлд орох цагаас нь эхлэн тэжээллэг арчилгаа маллагааг зөв зохион байгуулж ажилласнаар энэ жилээс эхлэн 2000 гаруй хургыг улсын бэлтгэлд тушаах бололцоог олжээ.

Авто машинуудыг үр ашигтай зүйлд зөв ашиглаж, 3 дугаар улирлын балансын дүнгээр авто тээврээс 401,3 мянган төгрөгийн орлогыг оруулаад байна.

Газар тариалангийн үйлдвэрлэл биеэ даасан том салбар болон хөгжиж, сүүлийн 2 жилд тариа тарих, хураах, хөрс боловсруулах бүх ажлыг нэгдэл өөрийн хүч хөрөнгөөр хийх болсон нь зохих үр дүнг өгч байна.

1969 онд 3650 га талбайд үр тариа, малын тэжээл, хүнсний ногоо, төмс тариалж 700 гаруй тонн улаанбуудай, 160 гаруй тонн арвайг улсад тушааж 109 шахам тонн төмс хүнсний ногоо хураан авчээ.

Уринш хагалах төлөвлөгөөг 180,5 хувиар биелүүлсэн нь ирэх жил өндөр ургац авах үндсэн нөхцлийг хангаад байна.

Нам, засгаас ХАА-н нэгдлийг бэхжүүлэх талаар авч явуулсан тууштай арга хэмжээ, Зөвлөлт анд нөхдийн өгөөмөр тусламжинд сум — нэгдлийн хөдөлмөрчид зоригжиж, улмаар В. И. Ленинийн мэндэлсний 100 жилийн ой, Ардын хувьсгалын 50 жилийн ой, ХАА-н нэгдэлчдийн 10 жилийн ойг угтаж, их амжилт бүтээл гаргахад итгэл төгс байна.

Тайлан сонгуулийн хуралд БНМАУ—ын нэгдлийн холбооны дээд зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга н.Ренчинсэнгэ оролцож дэлгэрэнгүй үг хэлэв.

**С. Чойндон**

**Б. Дамдин**

**Б. Сандаг**

Хариуцлагатай эрхлэгч **Н. МӨНХӨӨ**

## Зарлал

1969 оны жилийн эцсийн тооллого тооцоо хийх тул авто сэлбэгээр 12 дугаар сарын 20, шатахууны талоноор 25-наас эхлэн 1970 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл үйлчлэхгүй учир зарласан хугацаанаас өмнө хэрэгцээт зүйлээ авах, 1969 оны хоорондын тооцоог 1970 оны 1 дүгээр сарын 15-ны дотор 13 дугаар бааз, Тээврийг Удирдах газартай хийхгүй бол тээврийн байгууллагаас үйлчлэх үйлчилгээг зогсоохыг мэдэгдье.

**Тээврийг удирдах газрын захиргаа**

* * *

Багмид овогтой Бямбаа, Баярт овогтой Норсүрэн нарын гэрлэлтээ цуцлуулахаар гаргасан өргөдлийг 1 дүгээр хэсгийн шүүх хянаж байна.

(Х—00784) «Анхдугаар таван жил» сонины үйлдвэрт хэвлэв

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАНЖИЛ

Төв аймгийн намын хороо, А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

22 дахь жилдээ № 87 (1871) | 1969 оны 11 дүгээр сарын 20 | ПҮРЭВ

## ТӨРИЙН БА ХӨДӨЛМӨРЧДИЙН ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГА

Социализмын өрнүүн байгуулалтын одоогийн нөхцөлд социалист төрийн роль өсч ардчиллыг улам дэлгэрүүлэхийг шаардаж байна. Манай ардчилсан төр хөдөлмөрчдөд төр нийгмээ удирдах үйлст оролцох эрхийг үндсэн хуулиар олгож тууштай хэрэгжүүлж байна.

Энэ нь орон нутгийн ардын хурлуудын дэргэд идэвхтний биеэ даасан олон тоөны байгууллагууд ажиллаж түүнд олон мянган хөдөлмөрчид идэвхтэй оролцож байгаагаар нотлогдож байна.

Тус аймагт орон тооны биш хэлтэс, сум хороодын орлогч, эдийн засгийн зөвлөл, насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс, захиргааны комисс, цагдан сэргийлэхэд туслах олон нийтийн бригад, албан газруудын дэргэдэх олон нийтийн шүүх, орон сууц гудамжны хороо, ариун цэврийн комисс, гал эсэргүүцэх бүлгэм, эцэг эхийн хороо, зөвлөл, өмч хамгаалах зөвлөл, клуб, номын сангийн зөвлөл, анчдын нийгэмлэг, ахмадын ба охидын зөвлөл, ардын төлөөлөгчдийн зөвлөл зэрэг сайн дурын 30—аад байгууллагуудад олон мянган хүмүүс оролцон ажиллаж байна. Эдгээр олон нийтийн үүсэл санаачлага дээр үндэслэсэн байгууллагууд нь социалист хууль ёсыг биелүүлэх, социалист өмчийг хайрлан хамгаалах нийгмийн хэв журмыг сахиулах, ард иргэдээс нийгмийнхээ өмнө хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж нийгмийн дунд биеэ зөв авч явах явдлыг хангах, аж ахуйч биш байдал, хүнд суртал гаргах, хөдөлмөр таслах явдалтай шийдвэртэй тэмцэл явуулж, хөдөлмөрчдийг коммунист үзэл санаагаар хүмүүжүүлэхэд хамт олны нөлөөллийг хүчтэй болгож төрийнхөө ажилд туслаж байна. Эдгээр байгууллагын дотроос Баянзүрх, Их хайрхан, Жаргалант сумдын орон сууц гудамжны хороод, Эрдэнэсантын насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг эрхлэх комисс, Зуунмод хотын АДХ—ын Гүйцэтгэх Захиргааны дэргэдэх Лхагважав даргатай захиргааны комисс, аймгийн төвийн артелийн дэргэдэх Ядмаа даргатай олон нийтийн шүүх, Адъяатогтох даргатай аймгийн Сонины үйлдвэрийн дэргэдэх эх эцгийн зөвлөл зэрэг тэргүүний ажиллагаатай байгууллага, комисс олон байна. Их хайрханы хороо захиргаа орон сууц гудамжны хороодод ихээхэн туслалцаа үзүүлж зөв зохион байгуулж байна. Хорооны АДХ—ын гүйцэтгэх захиргааны гишүүд, ОСГ, хороодын дарга нараа 7 хоног тутам 1 өдөр гаргаж хүлээн авч ажлы нь зааварлаж, санал зөвлөлгөөний нь сонсдог байна. Баянзүрх суман дахь Амьтан ахлагчтай ЦСТОН-ийн бригад улирал, сарын төлөвлөгөөтэй, гишүүд нь ажлын хуваарьтай, хууль дүрмийн булан байгуулж түүгээрээ олон түмэнд сурталчлан ажилладаг байна.

Түүнчлэн энэ ажилд идэвхтэй оролцож байгаа Зуунмод хотын орон сууц гудамжны хорооны дарга Гажийс, Санжид, Жамбалдорж, ЦСТОН бригадын гишүүн Лувсангомбо, Лувсанжамц, Бал-Очир болон Борнуурын Дагва нарын олон гавшгай үйл ажиллагаатай идэвхтнийг нэрлэж болох бөгөөд ер нь цагдан сэргийлэхэд туслах олон нийтийн бригадын гишүүдийн олонхи нь үүргээ сайн биелүүлж байна.

Гэвч орон нутгийн АДХ, тэдгээрийн гүйцэтгэх захиргаадаас хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллагыг удирдах, ажлы нь шалган зааварлах, дэмжин туслаж идэвхжүүлэх, туршлагы нь солилцох, ажиллагааг нь судлан бүртгэх талаар тун хангалтгүй ажиллаж, тэдний өмнө тодорхой зорилт дэвшүүлэн тавьж цаг үеийн ажилд хүчий нь гүйцэд дайчилж чадахгүй урсгалд нь орхидгоос хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллагын ажил жигд сайжрахгүй байна. Ялангуяа Баянбараат, Дэлгэрхаан сумдын АДХ—ын гүйцэтгэх захиргаад энэ ажлыг маш хангалтгүй удирдаж байна. Мөн зарим сум хороодын АДХ-ын гүйцэтгэх захиргааны засаг захиргааны комисс, нилээд албан газрууд олон нийтийн шүүхүүдийн хүчийг зөв ашиглаж чадахгүй байхад дэргэдэх сумдын АДХ-ын гүйцэтгэх захиргаад, үйлдвэрчний байгууллага арга хэмжээ авахгүй байна. Пролетарийн диктатурын төрийн хөгжлөөр дэмжигдэн тавигдаж байгаа нийт ард түмний үүсгэл санаачлагыг хөгжүүлэх чухал хэлбэр төрийн ба хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллагын ажлыг сайжруулах нь ээлжиг зорилт болон тулгарч байна. Төрийн хэргийг удирдахад хөдөлмөрчдийг улам өргөн оролцуулж бүтээлч чанарыг нь цаашид дээшлүүлэх, төрийн аппаратын ажилд олон нийтийн үүсгэл санаачлагыг хөгжүүлэхэд орон нутгийн АДХ, тэдгээрийн гүйцэтгэх захиргаад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Энэ зорилтыг биелүүлэхийн тулд орон нутгийн АД хурлууд өөрсдийн эрхлэх ажлын онцлог эрх хэмжээндээ тохирсон олон арга хэлбэрийг ашиглаж болох байна. Орон нутгийн АДХ—ын байнгын комиссууд хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллагатай хамтран ажиллаж эрхэлсэн ажлын салбараар үйл ажиллагааны нэгдэл холбоог хангаж ажиллуулах нь чухал байна. АДХ-ын гүйцэтгэх захиргаадаас олон нийтийн байгууллагуудыг удирдахдаа тэдгээрийн дотоод буюу шууд ардчилалтай төрийн захиргааны төвлөн удирдах зарчмыг хослох ёстой. Мөн төрийн ба хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллагын эрх ашгийг тууштай хамгаалж дүрэм зааварт заагдсан үүрэг зорилтоо биелүүлэхэд нь дэмжин туслаж байвал зохино.

## АЙМГИЙН НАМЫН ХОРООНД

*Саяхан аймгийн Намын Хорооны Товчооны хурлаар МАХН—ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 177 дугаар тогтоолыг биелүүлэх арга хэмжээний тухай авч хэлэлцэв. Тус хурлаас БНМАУ—ыг тунхагласны 45 жилийн ойг энэ оны 11 дүгээр сарын 26-нд орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх тухай МАХН—ын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос саяхан гаргасан тогтоолыг биелүүлэх зорилгоор Аймгийн Намын Хорооны Товчооны хурлаас тогтоол гаргав. Уг тогтоолд дэлхий дахины амьдралд БНМАУ—ын эзлэх байр суурийн өсөлт бэхжилт, өнгөрсөн 45 жилийн ололт амжилт болон манай орны тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх талаар ЗХУ-аас үзүүлсээр байгаа ах дүүгийн төрөл бүрийн тусламжийн ач холбогдлыг өргөн сурталчлахын чухлыг заажээ. Мөн БНМАУ—ыг тунхагласны 45 жилийн ойг угтсан өндөр бүтээлийн 7,10 хоногийн ажлыг зохиож, улсын анхдугаар их хуралд оролцсон хүмүүстэй уулзалт хийх, дурьдатгал, дурсамжийг яриулах, үдэшлэг, хурал, цуглаан зохиох зэрэг ухуулгын олон хэлбэрээр энэ ажлыг сурталчлахыг нийт сумд, албан үйлдвэрийн газрын намын үүр, хороодын нарийн бичгийн дарга нарт үүрэг болгожээ.*

## БҮГД ХУРАЛ БОЛНО

Саяхан аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хурал хуралдаж ҮЭ-ийн зөвлөлийн III бүгд хурлыг хуралдуулах тухай тогтоол гаргав.

Уг тогтоолд: ҮЭ-ийн зөвлөлийн III бүгд хурлыг 1969 оны 12 дугаар сарын 8-нд аймгийн төвд хуралдуулахаар заажээ.

Тус III бүгд хуралд «Их ойнуудыг угтсан социалист уралдааныг улам эрчимжүүлье» гэсэн илтгэл хэлэлцэнэ.

Бүгд хурлыг 1969 оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг үзүүлэлт бүрээр нь тоо чанарын талаар биелүүлсэн өрнүүн амжилтаар угтах зорилгоор 20 хоногийн зохицтой ажил зохиохыг аймгийн үйлдвэр, аж ахуй, соёл үйлчилгээний байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгожээ.

**Манай сурвалжлагч**

## СЭДЭВТ АЖИЛ

Жаргалантын 10 жилийн дунд сургуулийн Зоя Космодемьянскаягийн нэрэмжит II бүлгэмийн бүлгийн зөвлөлийн гишүүдээс монгол хэвлэлийн 48 жилийн ой, шинэ оны хэвлэл захиалгын ажил явагдаж байгаатай холбогдуулан „Сонин ба хүүхэд" сэдэвт нээлттэй пионерийн ажлыг нийт пионер сурагчдын дунд явуулав.

Сэдэвт ажлаар пионерууд монгол хэвлэлийн байгуулагдсан түүх хөгжил, пионер сурагчдын дотны хэвлэл түүнд хэвлэгдсэн материалын талаар ярилцаж бодол сэтгэгдлээ солилцов. Энэ сэдэвт ажилд пионер Б. Батсүх, Думаа, Маам, Ганбаатар, Адъяасүрэн нарын олон пионер идэвхтэй оролцов.

**Д. Базаррагчаа**

## ӨВЛИЙН БЭЛТГЭЛЭЭ БАЗААЖ БАЙНА

Жаргалантын САА, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар шуурхайлан ажиллаж байна.

Тус сумын чуулганзар 9 дүгээр сард мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар хэлэлцэж энэ чуулгандаа бригад, фермийн дарга, сумын төвийн албан байгууллагын хариуцлагатан, мал аж ахуйн мэргэжилтэн, зарим суурийн ахлагчдыг оролцуулсан байна. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг чанартай сайн хангах ажлыг төлийн бэлтгэлийг хангах ажилтай нягт холбон зохиож өвөлжөө хаваржаанд өвс татах, хашаа саравч дулаалахад онцлон анхаарч сумын төвийн ажилчин албан хаагчид, сургуулийн сурагчдын дунд 3 өдрийн өндөр бүтээлийн ажлыг хэд хэдэн удаа зохион байгуулж ажилласан байна.

Мөн тус сумын нийт суурийн өвлийн бэлтгэлийг хангуулах зорилгоор сумын нам, захиргааны удирдлага, мал аж ахуйн мэргэжилтнүүд суурь бүрийг биечлэн шалгах 3 группийг явуулан шалгаж, зөвлөлгөө өгүүлэн ажиллажээ.

Тус сумын бог, бод малын 40 гаруй суурийн өвөлжөөнд 44 мянга гаруй мал өвөлжих бөгөөд энэ онд барих хашааныхаа төлөвлөгөөг 100 хувь, сумын хэмжээгээр энэ онд хадах хадлангийн төлөвлөгөөнөөс 790 тонн өвс илүү авчээ.

Өвөлжөө хаваржаанд 3700 тонн өвс татан авч нөөцөлсөн бөгөөд, суурь бүрт 30—40 тонн өвс, төллөх малын ба өсвөр малын суурьт 30 тонн өвс, төллөх малын суурьт 5—10 тонн сүрэл соломуудыг дэвсгэрт зориулан тус тус буулгаад байна.

Тус сумын хонь фермийн хоньчин, намын гишүүн М. Жав, хоньчин Цэдэндорж, намын гишүүн, үхэрчин Санжаа, Н. Рэнчин ахлагчтай хонин суурьнууд өвлийн бэлтгэлээ сайн хангасан байна.

**М. Намсрай**

